

Уламжлалт монгол орчуулгын эх бичгийг судлах асуудалд

/Төвд- монгол орчуулгын жишээн дээр/

Д.Бүрнээ* (МУИС)

Түлхүүр үг: уламжлалт орчуулга, эх бичиг судлал, эх зохиол, бар, гар бичмэл, хувилбар эх, хуулбар эх, хөрвүүлэг

Монголчууд түүхэндээ дэлхий дахины олон хэлнээс орчуулж байсан боловч төвд хэлнээс хамгийн он удаан жил орчуулсан бас хамгийн олон ном судар орчуулжээ. Энэ нь монголын буддын шашны утга зохиол төвд хэлээр уламжилж ирсэнтэй холбоотой. Монголын бурханы шашны дэлгэрлийн хоёрдахи үе гэж үздэг 13-14 дүгээр зууны үед төвд хэлнээс ном судар орчуулж эхэлсэн байх бөгөөд тэр үеийн орчуулгын дурсгал уйгаржин монгол бичиг болон дөрвөлжин бичгээр уламжилж иржээ. Бурханы шашны гуравдахи дэлгэрлийн үе гэж үздэг 16-17 дугаар зууны үед төвд хэл дундад зууны үеийн европ дахинд латин хэл эрдэм боловсролын үүрэг гүйцэтгэж байсны нэгэн адил үүрэг гүйцэтгэж ирсэн тул түүнийг дагаад төвд хэлээр ном бүтээл туурвих, төвд хэлнээс орчуулах үйл далайцтай өрнөв. Монгол орчуулгын томоохон дурсгал болох Ганжуур, Данжуур хэмээх буддын утга зохиолын их цоморлигийг монголчууд бүр 14 зуунаас орчуулж эхэлсэн бөгөөд 17-18 зууны хооронд орчуулж дуусгаад барлажээ. Буддын утга зохиолын энэхүү цоморлигт зохист аялгуу, хэл шинжлэл, анагаах ухаан, гүн ухаан, одон орон судлал, толь зүй гээд эрдэм ухааны олон салбарыг багтаасан 5000 гаруй зохиол оржээ. Энэхүү орчуулгын цоморлигийн бар болон бичмэл эх өнөө үед уламжлагдаж ирсэн байх бөгөөд дэлхий дахины номын сан болон манай улсын нийслэл хот, орон нутгийн номын сан, музей, сургууль хийгээд хувь хүмүүсийн цуглуулгад хадгалагдаж байна.

Төвд хэлнээс орчуулсан уйгаржин монгол бичиг болон тод бичгээр уламжилж ирсэн утга зохиолыг өнөө үед унших, судлах, шинэ кирил бичигт хөрвүүлэх ажил өрнөж байна. Энэхүү илтгэлдээ төвд хэлнээс монгол хэлнээ орчуулсан уйгаржин монгол бичгээр буй дурсгалын эх бичгийг судлах талаар өөрийн хийсэн зарим ажиглалтын тухай өгүүлэх болно.

*МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг, алтай судлалын тэнхим, профессор, доктор

Гадаад дотоодын эрдэмтэн мэргэд монгол орчуулгын эх бичгийг судлах талаар хийсэн ажиглалт дүгнэлтийг энд нэгтгэн авч үзэх зорилго тавьсангүй. Харин зарим эрдэмтний санаа оноо, туршлагыг ямар нэгэн хэмжээгээр энэхүү өгүүлэлдээ эшилсэн болно.

Орчуулга судлалын ухаан эх бичгийн судлалтай нягт холбоотой. Ялангуяа төвд хэлнээс хийсэн орчуулгын эх бичгийн тухайд онцлог бий. Тухайн орчуулгын эх бичгийн хувьсал хөгжлийг эх зохиол, гар бичмэл, бар хэвлэл, хувилбар болон хуулбар эх, төгсгөлийн үг, хөрвүүлэг тэргүүтнээс харах боломжтой. Орчуулгын эх бичгийн түүхэн хувьсал бол орчуулгыг утга зохиол судлалын үүднээс нарийвчлан авч үзэх тулгуур болно.

Орчуулгын эх зохиолын тухай

Аливаа орчуулгын судлал зайлшгүй эх зохиолыг судлахаас эхлэх учиртай. Үүний тул эх зохиолын бар болон бичмэл эхүүдийг бүртгэн цуглуулах нь арга зүйн талаас ач холбогдолтой. Учир нь зарим эх зохиол цагийн эрхээр олдохгүй болсон байх тул хувилбар эхийг ашиглахад хүрдэг. Тухайлбал монгол Ганжуурын 90-р ботид буй “Үлгэрийн далайн” Ширээт гүүшийн орчуулгын төвд эх одоогоор олдоогүй. Ширээт гүүшийн орчуулгын төвд эх бол төвд Ганжуураар уламжилж ирсэн “Занлүн” судрын эхээс бүтцийн талаар ялгаатай, хэл найруулгаараа ч өөр эх болох нь Ширээт гүүшийн орчуулгаас харагдана. “Үлгэрийн далайн” төвд эх яагаад олдохгүй байна вэ? Анх санскрит хэлээр “Дамамука” нэртэйгээр зохиосон “Занлүн” судрын Дэргэ, Нартан, Хүрээ барын төвд эхийн төгсгөлийн үгд “хятад хэлнээс орчуулав” гэсэн бол монгол орчуулгын төгсгөлийн үгд төвд эхийг санскрит хэлнээс орчуулсан гэж тэмдэглэжээ. Төвд Ганжуур, Данжуур дахи олон номыг санскрит буюу хятад хэлнээс орчуулсан байх тул төвд эхийн онцлогийг судлах цаашлаад монгол орчуулгын эх зохиолын тухай авч үзэхэд төвд эх зохиолыг ямар хэлнээс орчуулсан тухай асуудлыг хөндөх шаардлагатай болж байна. Гэтэл санскрит эх олдохгүй, хятад орчуулга буюу “Шэнь-Юй-жин” хэмээх судар бүтцийн хувьд төвдөөс ялгаатай, төвд эх зохиол олдохгүй байгаа тохиолдолд хувилбар эхийг ашиглах боломжтой бөгөөд энэ нь ямар нэг хэмжээгээр тухайн орчуулгын судлалд нэмэртэй. “Занлүн” судрын хувилбар эхэд төвд Ганжуурын олон зүйл бар болон бусад хэвлэлийг авч үзэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл орчуулгын эх бичгийн судлалд төвд эх зохиолын олон барыг бүртгэж харьцуулах нь эхийн түүхэн хувьслыг судлах үндэс суурь болж байгаа билээ.

Орчуулгын эхүүд дэхи утгын зөрөөтэй үг хэллэгийг эх зохиолын эхээр тодлох боломжтой. Энэ талаар ахмад эрдэмтдийн хийсэн туршлагаас авч үзвэл Ц.Дамдинсүрэн гуай “Рамаяна Монголд дэлгэрсэн нь” хэмээх нэг сэдэвт бүтээлдээ “Рамаяна”-гийн гол баатрын нэр Сита хатны нэрийг төвд хэлнээс монгол хэлнээ хэдэн янзаар орчуулсан байдгийг тэмдэглээд “Үхлэн дуудагч” гэж буруу орчуулсан нь төвд эхийн “rol myed ma” хэмээх оноосон нэрийн бичлэгээс үүдсэн болохыг тэмдэглэсэн нь бий.

Монгол орчуулгын эхийг судлахад баларч арилсан, зарим харь гаралтай үг, хуучирсан үг хэллэгийг зөв унших, алдаа мэдгийг залруулахад төвд эх чухал үүрэгтэй.

Тухайлбал: "Таравчэнбо" хэмээх төвд хөлгөн судрын монгол Ганжуураар уламжилж ирсэн орчуулгын бичлэгийг авч үзвэл

- баларсан үг цөөнгүй бий. Жишээ нь: монгол Ганжуурын 83 дугаар ботийн 2556 талд "эрт түүнчлэн ирэгсдэд мөргөснөөр амьтан.....хаалгыг таславай хэмээн сонслоо" гэж үг орхисон байх бөгөөд үүнийг бид төвд эхээр магадлаж "тамын" /dmyal ba'i/ гэсэн үг болохыг тодолж байгаа юм.
- харь гаралтай үг олон бий. Жишээ нь: "сав лога даду" гэсэн үг байна. Энэ үг бол төвд эхийн "ми жэд" /mi mjed/ гэсэн үгийн "sahāloka dhātu" хэмээсэн санскрит хөрвүүлэг болохыг төвд- санскрит, санскрит- төвд толь бичгээс нягталж болно.

Сүүлийн үед гарч буй зарим хөрвүүлгэд төвд эхтэй тулгаж магадлаагүйгээс буруу буулгасан зүйл тааралдана. Тухайлбал "Таравчэнбо" судрын нэгэн хөрвүүлгэд дээрхи үгийг "савлагаат ертөнц" гэж буулгажээ. Энэ ташрамд тэмдэглэхэд эхийн алдааг судлах талаар эрдэмтэн багш Ц.Шагдарсүрэнгийн хийсэн судалгааг бид монгол Ганжуур, Данжуурын эхийг судлахад авч хэрэглүүштэй.

Орчуулгын гар бичмэлийн тухай

Төвд хэлнээс эрт үед орчуулж, хожим монгол Ганжуурт эмхтгэсэн орчуулга бар болон гар бичмэлээр өргөн тархсан байна. Тухайлбал эрдэмтэн Ц.Дамдинсүрэн гуай "Алтангэрэл" судрын Шаравсэнгийн орчуулгын бар болон бичмэл 30 орчим эх, төвд "Шидэт хүүрийн үлгэрийн" 27 гар бичмэлийг бүртгэсэн байдгийг бид мэднэ. Ийнхүү бүртгэн үзээд Ц.Дамдинсүрэн гуай "Шидэт хүүрийн үлгэрийн" гар бичмэлүүдийг агуулга, хэл найруулгаар нь 7 зүйл хувилбар болгож ангиалан хувааснаас гадна төвд эх бүхий 10 зүйл гар бичмэлийг бүртгэсэн нь "Шидэт хүүрийн үлгэрийн" монгол орчуулгыг судлахад чухал гарын авлага болох юм.

Бичмэл эх орчуулгын эх бичгийн судлалд чухал үүрэгтэй. Ялангуяа орчуулагчийг тодруулах, орчуулсан он цагийг тодлоход бидэнд чухал хэрэглэгдэхүүн болох юм. Тухайлбал "Үлгэрийн далайн" ОХУ-д хадгалагдаж буй бичмэл эхийн төгсгөлийн үгээс бар хэвлэл болон бусад бичмэл эхийн алинд ч байхгүй мэдээ буюу тус судрыг Ширээт гүүш орчуулсныг оросын эрдэмтэн Б.Я. Владимирцов олж мэдсэн байдаг. Түүнчлэн монгол бичмэл Ганжуурын төгсгөлийн үгээс бид дармал Ганжуурын дотор нэр дурдагдаагүй хорин зургаан хэлмэрчийн алдрыг тодруулж байгаа билээ.

Орчуулгын төгсгөлийн үгд дурдсан түүхэн хүмүүсийн талаарх мэдээ орчуулгын он цагийг тодолж өгч байна. Нэг зохиолын олон орчуулга монгол орчуулгын эх бичгийн судлалд бас холбогдож байгаа бөгөөд монгол орчуулгын эх бичиг дэхи үг утгын зөрөөг тайлахаас гадна хэл найруулгыг харьцуулж, онцлогийг тодруулах боломжтой. Тухайлбал: "Субашидийн" олон орчуулга дотроос Сономгарагийн орчуулга эртний монгол хэлний онцлогийг илүү их хадгалсан байдгийг бусад орчуулгатай харьцуулбал илүү тодорхой харагдах жишээтэй.

Орчуулгын ноорог

Орчуулгын эх бичгийг судлахад гар ноорог их үүрэгтэй. Тухайлбал Шагж гуайн "Дунта шэлжи мэлон" /Болорын толь/ хэмээх зохиолын орчуулгын хэдэн зүйлийн эх өөрөөр хэлбэл ноорог эх, хуулбар эх, эцсийн эх буюу орчуулга манай улсын Үндэсний номын санд хадгалагдаж байна. Энэхүү нооргийг ажиглахад орчуулагч үг хасаж бөгөөд орчуулагч эхийг хэрхэн яаж ойлгож, үгийг хэрхэн сонгож, хэрхэн найруулж бичсэн тэргүүтнийг тодорхой харах боломжтой.

Монгол бичмэл Ганжуурын эх бол дармал Ганжуурын эхийг судлахад бас чухал хэрэглэгдэхүүн болох юм. Тус эхийн дотор үг хасаж дарсан, балласан, үг нэмж шинж ажиглагдана. ОХУ-ын Санкт-Петербург хотын Улсын Их сургуулийн Дорно маягаар бэлтгэсэн эх болохыг судлаачид тэмдэглэжээ. Тиймээс монгол Ганжуурын эх бичгийг судлахын тулд бичмэл Ганжуурыг бас үзэх хэрэгтэй юм.

Орчуулгын хөрвүүлэг

Монгол орчуулгын хөрвүүлэг эх бичгийн судлалд холбоотой. Манай уламжлалт орчуулга уйгаржин монгол бичгээр уламжилж ирсэн тул эдгээр судрыг өнөөгийн уншигчдад зориулж кирил бичгээр хөрвүүлэн буулгаж байна. Ийнхүү хөрвүүлэн буулгахад орчуулгын гар бичмэл болон бар хэвлэл тэргүүтнийг үзэж олон зүйл эхээс хамгийн алдаа мадаг багатай эхийг олж буулгавал зохилтой. Ер нь орчуулгыг кирил бичигт хөрвүүлэн буулгаж хэвлэх ажил бол орчуулгын эх бичиг судлалын эцсийн шатанд хийх ажил билээ. Гагцхүү сүүлийн үеийн зарим хөрвүүлгийг ажиглавал орчуулгын эх бичгийг судлахгүйгээр хэвлэснээс алдаатай буулгасан зүйл цөөнгүй харагдаж байна.

Монгол орчуулгын хөрвүүлгэд санскрит гаралтай үгийг хэрхэн кирил бичигт буулгах, санскрит бичлэгийг баримтлах эсэх /тухайлбал бодьсад гэж эхийг барьж буулгах уу, эсвэл санскрит бичлэгийн дагуу "бодьсатва" гэх буулгах уу/, хэл зүйн хэлбэрийг хэвээр буулгах уу, эсвэл орчин цагийн монгол хэлний зүйн дагуу буулгах уу зэрэг асуудал гарна. Энэ асуудлыг нэг мөр болгож журамлан тогтоох нь эх бичиг судлалын асуудлыг нааштай шийдвэрлэхэд тус нэмэр үзүүлнэ. Нэн ялангуяа үг утгын алдаа мадагтай хөрвүүлгийг засаж залруулахгүй бол бурханы шашны ном судрыг сурталчлах бус харин ойлгохгүй хүний тоог нэмэхээс өөр зүйлгүй болох болов уу.

Товчлол

Монголчууд 13-14 зуунаас өнөө үе хүртэл төвд хэлнээс арвин их ном судар орчуулсан билээ. Эдгээр орчуулгын эх бичгийг судлах нь хэл бичиг судлалын үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн болж байна. Төвд-монгол орчуулгын эх зохиол, гар бичмэл, хуулбар, хувилбар эх, хөрвүүлэг нь эх бичгийг судлахад чухал үүрэгтэй. Тухайлбал: орчуулгын эх зохиол орчуулгын алдаа мадагтай хөрвүүлгийг залруулах, баларч

арилсан үг хэллэгийг сэргээх, харь гаралтай үг хэллэгийг тодлох боломжийг өгч байгаа бол зарим бичмэл эх бусад эхэд байхгүй шинэ мэдээг агуулж байна. Орчуулгын эх бичгийг судлахын эцсийн зорилго бол түүнийг хэвлэн нийтлүүлэх явдал юм. Гагцхүү сүүлийн үед орчуулгын эх зохиол, бичмэл эх, хуулбар хувилбарыг судлахгүй хэвлэснээс алдаа мадагтай хөрвүүлэг цөөнгүй гарч байна.

Резюме

Монголы начиная с 13-14 века до сегодняшнего дня перевели с тибетского языка множество книг. Текстология этих переводных произведений является базой филологии. Подлинник, рукопись, список, черновик, переложение монгольских переводов со старописьменного языка на кириллицу имеют важное значение в изучении текста. Так например, если подлинник способствует выявлению ошибок, восстановлению неразборивых слов, разъяснению заимствованных слов из санскрита, то в рукописи можно обнаружить новые данные о переводчике. Конечной целью текстологии переводных произведений является его издание. К сожалению в последнее время выходят в свет немало переводных произведений, которые нуждаются в изучении текстологии.